



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/113

Цагаан-Уул сум

Г Хүлээн авах комисс томилох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн Өвгөд багийн Оргомчийн буланд харуулын байр барих ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ахлагч: Б.Дэлгэрмөрөн (Өвгөд багийн Засаг дарга)

Гишүүд: Ж.Бадрал (Архив бичиг хэргийн ажилтан)

Б.Батсуурь (Байгаль хамгаалагч)

Б.Ариунболд (Байгаль хамгаалагч)

Нарийн бичгийн дарга: М.Бямбасүрэн (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

2. Техникийн тодорхойлолтын дагуу дээрх ажлыг хүлээн авч, тэмдэглэл үйлдэж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Дэлгэмөрөн)-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ ДАРГА

У.АВАРЗЭД